

Сонгинохайрхан дүүрэг

"Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн
ба хэрэгцээ шаардлага"
Түргэвчилсэн судалгаа

2022 оны 7-р сар



© З.Эрдэнэ



Агуулга

Удиртгал ба аргачлал	1
Мэдээллийн дүн шинжилгээ.....	2
1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм.....	2
1.2 Ирсэн иргэд.....	3
1.3 Явсан иргэд.....	3
1.4 Хөдөлмөр эрхлэлт.....	4
1.5 Санхүүгийн нөхцөл байдал.....	5
1.6 Тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал.....	6
1.7 Үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц.....	10
1.8 Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж.....	14
1.9 Тээвэр, замын хөдөлгөөний нөхцөл байдал.....	15
1.10 Хүүхэд болон боловсрол.....	16

Удиртгал ба аргачлал

Удиртгал

Дүүргийн түвшний энэхүү тайланд 2022 оны 3-р сард Улаанбаатар хотын хэмжээнд хүн ам, шилжилт хөдөлгөөн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шуурхай үнэлгээнд тусгагдсан үндсэн болоод сэдэвчилсэн бүх чиглэлийн тойм мэдээллийг багтаасан болно.

Энэхүү тайлан нь Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд найман үндсэн сэдвийг хамарсан судалгааг багтаасан; тухайлбал, хүн амын суурь тоон үзүүлэлт, хүн ам зүй, ирсэн болон явсан иргэд (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд ба аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, хүүхэд болон боловсрол гэх мэт. Мэдээллийг дүүргийн нутаг дэвсгэр, хүний нөөц, засаг захиргааны нэгжийн харилцааны талаарх мэдлэг өндөртэй мэдээлэл нэгтгэгчид болох хэсгийн ахлагч нартай ярилцлага хийх замаар олж авсан.

Энэхүү судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын дэлгэрэнгүй тайлангаас авч үзнэ үү.

Аргачлал

Энэхүү тайланд ОУШХБ-ын Шилжих хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн нэгжээс боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараас мэдээллийг цуглуулав. Хэсгийн ахлагч нар иргэдтэй ярилцах, ажиглалт хийх болон өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан, харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөсөн. Хэсгийн ахлагч нарыг хүн амын суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхэд ба боловсрол гэсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны асуулгыг бөглөхийг хүссэн юм.

Хэсгийн ахлагч нар Кобо программ хамгамжаар дамжуулан тоон мэдээллийг гар утас эсвэл таблет, компьютер ашиглан бөглөж илгээсэн. Хэсгийн ахлагч нарыг ДТМ судалгааны аргачлал, судалгааны асуулга, түүнийг нөхөхтэй холбоотой танхимын сургалтад бүрэн хамруулсан. Түүнчлэн ДТМ-ийн баг мэдээлэл цуглуулах явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.


Өгөгдөл оруулах үйл явц албан ёсоор хаагдмагц ДТМ-ийн баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд өгөгдөл оруулахад гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг хийсэн. Өгөгдөлтэй холбоотой аливаа асуудал илэрсэн тохиолдолд ДТМ-ийн баг тодруулга авахаар хэсгийн ахлагч нартай утсаар холбогдож тоон мэдээллийг тодруулж, баталгаажуулсан байна. Бүх хяналт, шалгалтыг хийж дууссаны дараа мэдээлэлд дүн шинжилгээ хийх үе шатанд шилжсэн. Бүх судалгааны үр дүнг хэсгийн түвшинд дүн шинжилгээ хийж, дараа нь дүүргийн болон хотын хэмжээнд нэгтгэн дүгнэв. Иймээс дүүрэг, хотын түвшинд энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд ч авах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

Хязгаарлагдмал байдал, судалгааны аргачлалын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын хэмжээний нэгдсэн тайлангаас үзнэ үү.




1. МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ-СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм



Хүн ам зүй (эзлэх хувь)




Үнэлгээ хийх үед (2022 оны 3-р сар) Сонгинохайрхан дүүрэгт 335,554 иргэн буюу 89,725 өрх амьдарч байв. Сонгинохайрхан дүүргийн хувьд Улаанбаатар хотын хүн амын 22 хувь оршин суудаг, хүн амаараа хоёрдугаарт ордог дүүрэг юм. Үүнээс 48 хувь нь эрэгтэй, 52 хувь нь эмэгтэй байв. Хүн амын 33 хувь нь насанд хүрээгүй гэж бүртгэгдсэн, 10 хувь нь 0-5 насныхан, 24 хувь нь 6-17 насныхан байна. Хүн амын 61 хувийг 18-65 насны насанд хүрэгчид, 5 хувийг өндөр настан (65-аас дээш насныхан) эзэлж байна.

Нийтдээ 5,228 хүн архаг хууч эсвэл хүнд өвчтэй (хүн амын 1,6%), 3,079 эмэгтэй (эмэгтэйчүүдийн 1,8%) жирэмсэн гэж бүртгэгджээ.

Сонгинохайрхан дүүрэг нь 43 хороо, 355 хэсэгтэй. Хүн ам нь 43 хороонд харьцангуй тэгш тархан суурьшдаг, гэхдээ 33-р хороонд хүн амын 5% оршин суудаг, хамгийн олон хүн амтай, дараа нь 37, 22-р хороо (тус бүр 4%) орж байна.


Хүн ам зүйн тойм хүйсээр, хороогоор (эзлэх хувь)



1.2 Ирсэн иргэд²

Сонгинохайрхан дүүрэгт 2021 онд нийт 7,846 өрх буюу 25,398 иргэн ирсэн. 2021 онд Улаанбаатар хотод нийт ирсэн иргэдийн 21.2% нь Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн бол хамгийн өндөр хувь нь 33-р хороонд (10%) байна. Энэ дүүрэгт ирсэн гол шалтгаан нь гэр бүл (24%), дараа нь боловсрол (21%), эдийн засгийн (20%) шалтгаан байна.


Ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)




1.3 Явсан иргэд

Сонгинохайрхан дүүргээс 2021 онд нийт 5,787 өрх буюу 21,878 иргэн явсан. 2021 онд Улаанбаатар хотын хэмжээнд явагсдын 25.3 хувь нь Сонгинохайрханд бүртгэгдсэн нь нийслэлийн хэмжээнд хамгийн олон хүн явсан дүүрэг болж байна. Хамгийн өндөр хувь нь 5-р хороо (10%), 1-р хороо (8%), 31-р хороо (7%) ноос явсан байна. Ерөнхийдөө энэ дүүргээс явах үндсэн шалтгаан нь орон байрны шалтгаан буюу ашиглалтад орсон орон сууцанд амьдрах (28%) байв.

Явсан иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)



Ирсэн, явсан үндсэн шалтгаанууд (эзлэх хувь)




² Ирсэн иргэд гэдэг нь Улаанбаатар хотын дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран Улаанбаатар хотын аль нэг байршилд оршин суухаар ирсэн иргэн, айл өрхийг хэлнэ. Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль нэг байршилаас явсан эсэхийг үл хамааран явсан иргэн, айл өрхийг хэлнэ.


1.4 Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн тэргүүлэх салбар нь барилга (хэсгүүдийн 35%), бөөний болон жижиглэнгийн худалдаа (хэсгүүдийн 22%), үйлдвэрлэл (хэсгүүдийн 15%) байна. 11-р хороо (хэсгүүдийн 100%), 10-р хороо (хэсгүүдийн 90%), 24-р хороо (хэсгүүдийн 82%)-нд барилгын ажил нь үндсэн хөдөлмөр эрхлэлтийн салбар гэж мэдээлжээ. Барилга нь хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар болох хэсгүүдэд нийтдээ 109,505 иргэн (дүүргийн хүн амын гуравны нэг) амьдардаг. Бөөний болон жижиглэнгийн худалдаа нь 17-р хороо (хэсгүүдийн 100%), 12-р хороо (хэсгүүдийн 100%), 8-р хороо (хэсгүүдийн 75%)-нд хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар гэж мэдээлжээ. Бөөний болон жижиглэнгийн худалдаа нь хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар болдог хэсгүүдэд нийтдээ 80,657 хүн (дүүргийн хүн амын бараг дөрөвний нэг) амьдарч байна.


Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар (хэсгийн эзлэх хувь)




Хөдөлмөр эрхлээгүй хүн ам (18-64 насны иргэдийнн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь, хороогоор (18-64 насны иргэдийнн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлэлтийн төрөл (хэсгийн эзлэх хувь)



Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд 18-64 насны 60,896 хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа нь насанд хүрсэн хүн амын 30 хувийг эзэлж байна. Хэдийгээр энэ нь хүн ам ихтэй дүүрэг учраас хотын хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь тэнцүү байгаа боловч нийт хөдөлмөр эрхлэх насны хүмүүсийн 23% нь хөдөлмөр эрхэлдэггүй бөгөөд ажил хөдөлмөр хийгээгүй байгаа иргэдийн тоогоороо нийслэлийн хэмжээнд хоёрдугаарт орсон юм. Хөдөлмөрийн насны хүн амын тал шахуу хувь нь (49%) хөдөлмөр эрхлээгүй 33-р хороо, мөн 42, 20-р хороо (тус бүр 47%)-нд хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь хамгийн өндөр байна. Тэдгээр гурван хороонд хөдөлмөрийн насны нийт 16,891 иргэн байгаагаас 8,066 нь хөдөлмөр эрхлээгүй гэсэн мэдээлэл байна. Харин эсрэгээрээ 29-р хороонд хөдөлмөрийн насны хүн амын 95 хувь (5,158 иргэнээс 4,914), 34-р хороо (94%), 17-р хороонд (91%) хөдөлмөр эрхэлдэг тул хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь хамгийн бага байна. Тэдгээр гурван хороонд хөдөлмөрийн насны нийт 13,707 хүн ам байгаагаас 12,859 нь хөдөлмөр эрхэлдэг гэсэн мэдээлэл байна.

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд нийт иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хувьд 75 хувьд хувийн хэвшил зонхилж, 9 хувьд нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 7 хувьд нь төрийн албанд ажилладаг гэж мэдээлсэн байна. Сонгинохайрхан дүүрэг нь Улаанбаатар хотын бусад дүүрэгтэй харьцуулахад хувийн хэвшлийн салбарт хөдөлмөр эрхлэгчдээрээ нийслэлийн хэмжээнд хоёрдугаарт орж байна. Мөн төрийн албанд хөдөлмөр эрхлэгчид дунджаас доогуур байгааг мэдээлжээ (хотын дунджаас найман хувийн пунктээр бага). Хувийн хэвшил 1, 3, 4, 5, 8, 10, 11, 12, 22, 23, 25, 28-р хороодын бүх хэсэгт байдаг гэж мэдээлжээ. Төрийн алба 18-р хороо (хэсгүүдийн 43%), 19-р хороо (хэсгүүдийн 30%), 7-р хороо (хэсгүүдийн 29%)-нд хамгийн их бүртгэгдсэн байна.

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд хүнсний хүртээмжтэй байдлыг хоёр үзүүлэлтээр үнэлэхэд маш хүндрэлтэй, ихээхэн санаа зовнил үүсгэж байгаа асуудал болох нь харагджээ.

Ерөнхийдөө, дүүргийн нутаг дэвсгэрт байгаа хэсгүүдийн 51 хувьд нь мэдээлэгчид мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд өрхүүд хангалттай хоол хүнсгүйдээ санаа зовж байгааг мэдээлсэн нь хотын дундаж болох 29%-аас 21 хувийн пунктээр илүү байна. Нийтдээ 167,112 хүн ам ингэж нөлөөлсөн хэсэгт амьдарч байгаа нь Улаанбаатар хотын хэмжээнд иргэдийн 41 хувийг эзэлж байна. 29, 39-р хороод хамгийн их өртөж байгаа бөгөөд бүх хэсгийн мэдээлэгчид айл өрхүүд хоол хүнс хангалтгүй байна гэсэн санаа зовнилоо илэрхийлсэн талаар мэдээлжээ.

Хэсгүүдийн 60 хувьд нь мэдээлэгчид мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд айл өрхүүд хүнсний хэрэглээгээ багасгасан тухай сонссон гэж мэдээлсэн нь хотын дундаж болох 34 хувиас 26 пунктээр өндөр байна. Нийтдээ 196,878 хүнсний хэрэглээгээ багасгасан хэсэгт амьдардаг бөгөөд энэ нь хотын хэмжээнд өндөр байна. 8, 22, 29, 30, 39-р хороод үүнд хамгийн их өртөж байгаа бөгөөд бүх хэсгийн мэдээлэгчид айл өрхүүд хүнсний зардлаа бууруулж байгаа тухай мэдээлжээ.

Хүнсний хүртээмжтэй байдал (хэсгийн эзлэх хувь)


Хүнсний хэрэглээ хангалтгүй байгаад санаа зовних




Хүнсний хэрэглээгээ багасгасан



Сүүлийн 4 долоо хоногт орлого нь буурсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



Сүүлийн 4 долоо хоногт бүх орлогоо алдсан иргэд (хэсгийн эзлэх хувь)




Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрийн 70 хувьд нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд нийт оршин суугчдын талаас бага нь буюу бараг хэн ч орлого буураагүй гэж мэдээлсэн байна. Гэхдээ хэсгүүдийн 30 хувь нь оршин суугчдын тал буюу талаас илүү хувь нь орлогоо алдаж, энэ нь 98,662 хүнд нөлөөлснийг мэдээлж байна. Цаашилбал, мэдээлэгчид хэсгүүдийн 23 хувьд оршин суугчдын тал буюу талаас илүү хувь нь мэдээлэл цуглуулахаас дөрвөн долоо хоногийн хугацаанд бүх орлогоо алдаж, энэ нь 74,150 хүнд нөлөөлсөн гэж мэдээлжээ.

1.6 Тулгамдаж буй асуудал болон аюулгүй байдал

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд хамгийн тулгамдсан асуудал нь санхүү, эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотой харагдаж байна. Хамгийн их мэдээлсэн тулгамдсан асуудал нь орлого хангалтгүй (хэсгүүдийн 53 хувьд мэдээлсэн), дараа нь тухайн хэсгийн хөдөлмөр эрхлээгүй хүн ам (23%), өр (14%) их байна гэж мэдээлсэн юм. 3, 14, 17, 25 дугаар хороодод орлого хангалтгүй байна гэсэн санаа зовнил байгааг хороодын бүх хэсэгт мэдээлжээ.


Тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд иргэдийн амьжиргаа, ажлын байр, орлого бий болгох боломж (31%), эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж (17%), автомашины зогсоол (12%) зэрэг үйлчилгээг авахад хамгийн хүндрэлтэй байсан байна. 24-р хорооны хэсгүүдийн 73 хувьд нь амьжиргаа, ажлын байр, орлого бий болгох боломж нь нэн тэргүүнд анхаарал хандуулдаг асуудал байсан бол 14, 29-р хорооны бүх хэсэгт авто машины зогсоолтой болох асуудал хамгийн их анхаарал хандуулах шаардлагатай асуудал байв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй гол бэрхшээл нь тусгай зориулалтын эмнэлгийн тусламж үйлчилгээ (40%), хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай тээврийн үйлчилгээ дутмаг (29%) байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгамдаж буй асуудал (хэсгийн эзлэх хувь)




Хүндрэлтэй байдаг үйлчилгээ (хэсгийн эзлэх хувь)




Аюулгүй байдал, хороогоор

Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн



Аюулгүй байдлыг хөндсөн асуудал гарсан эсэх (хэсгийн эзлэх хувь)


Аюулгүй байдлыг хөндсөн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.7 Дэд бүтэц, үйлчилгээ

УС

Усны хэрэглээгүй байгаа хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Устай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Цахилгааны хэрэглээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Цахилгааны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ХООЛ, ХҮНС

Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнс тэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ОРОН БАЙР

Орон байрны хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Орон байртай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.7 Дэд бүтэц, үйлчилгээ



ХҮНСНИЙ БУС ЗҮЙЛС



ИНТЕРНЭТ



ЭРҮҮЛ МЭНД



УХААЛАГ УТАС




1.8 Ногоон байгууламж

Мэдээлэл нэгтгэгчээс өөрийн хэсгийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанарт нэгээс тав хүртэл, нэг нь маш муу, тав нь маш сайн гэсэн үнэлгээ өгөхийг хүссэн.


Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар (хэсгийн эзлэх хувь)

Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш


Өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар



Хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар



Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




Нийслэлийн дунджаас доогуур үнэлэгдсэн ногоон байгууламжтай хороо


Өрхийн ногоон байгууламж Хороо #1	Хувийн хэвшлийн ногоон байгууламж Хороо #1	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж Хороо #1
Хороо #5	Хороо #3	Хороо #3
Хороо #6	Хороо #5	Хороо #5
Хороо #7	Хороо #6	Хороо #6
Хороо #11	Хороо #7	Хороо #7
Хороо #16	Хороо #8	Хороо #8
Хороо #17	Хороо #11	Хороо #10
Хороо #22	Хороо #17	Хороо #11
Хороо #23	Хороо #22	Хороо #22
Хороо #26	Хороо #24	Хороо #23
Хороо #27	Хороо #26	Хороо #24
Хороо #28	Хороо #27	Хороо #27
Хороо #29	Хороо #28	Хороо #31
Хороо #33	Хороо #29	Хороо #32
Хороо #34	Хороо #32	Хороо #33
Хороо #35	Хороо #33	Хороо #34
Хороо #36	Хороо #34	Хороо #35
Хороо #37	Хороо #35	Хороо #36
Хороо #38	Хороо #36	Хороо #38
Хороо #40	Хороо #38	Хороо #40
Хороо #41	Хороо #40	Хороо #41

1.9 Зам тээвэр ба хөдөлгөөн

Хувийн тээврийн хэрэгсэлгүй өрх (хэсгийн эзлэх хувь)



Тээврийн үндсэн аргууд (хэсгийн эзлэх хувь)



Замын хөдөлгөөнтэй холбоотой үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь %)



Сонгинохайрхан дүүрэгт автобус, микро автобус нь зонхилох тээврийн хэрэгсэл байсан бөгөөд нийт хүн амын тал болон түүнээс дээш хувь нь хувийн тээврийн хэрэгсэлгүй гэж мэдээлсэн байна. Замын хөдөлгөөнтэй холбоотой хамгийн хүндрэлтэй асуудал нь хүүхдийн тоглох нийтийн талбай дутмаг (19%), энэ нь 39-р хороонд хамгийн их бүртгэгдсэн (71%), дараа нь авто машины зогсоол дутмаг (16%), энэ нь 16, 12-р хороодод хамгийн их (75%) бүртгэгдсэн байна.



© У.Одбаяр

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: Шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх; шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх зэрэг болно.



Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Судалгааны аргачлал, арга зүй, дүн шинжилгээ, тайланг загварчлах ажлыг ОУШХБ-ын ДТМ хариуцсан ОУ-ын зөвлөх Витторио Бруни, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтох, туслах ажилтан Болор-эрдэний Маналцогзолын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгыг ОУШХБ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн удирдлагуудын техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.

1.10 Хүүхэд ба боловсрол


Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд 0-5 насны 11,390 хүүхэд цэцэрлэгт хамрагдаагүй (тухайн насны хүн амын 30%), 6-17 насны 1,468 хүүхэд (тухайн насны хүн амын 2%) сугуульд хамрагдаагүй байна. Дүүргийн хэмжээнд 0-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаагүй хувь нийслэлийн дундажтай ижил, харин 6-17 насны хүүхдүүдийн боловсролд хамрагдаагүй түвшин нь нэг хувиар бага байна. 0-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаагүй түвшин нь 11-р хороонд 57 хувь, 6-17 насны хүүхдүүдийн боловсролд хамрагдаагүй түвшин хамгийн өндөр 15-р хороонд 24 хувьтай байна.

Хүүхдүүдийн ерөнхий нөхцөл байдлыг илүү өргөн хүрээнд судлахын тулд мэдээлэл нэгтгэгчээс хүүхдүүдэд тулгардаг үндсэн асуудал өөрсдийн хэсгийн нутаг дэвсгэр дээр хэр байгаа талаар асуусан. Сонгинохайрхан дүүргийн хэсгүүдийн 43 хувь нь боловсролтой холбоотой асуудал байхгүй гэж хариулсан бол 28 хувь нь сургуулиуд хэт хол байна гэж хариулжээ. Дүүргийн хэмжээнд хүүхдүүдтэй холбоотой хамгийн их бүртгэгдсэн хоёр асуудал бол хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх клуб, спортын төв дутмаг (хэсэгүүдийн 45%) болон сургууль хэт хол (18%) юм.

Сургуульд хамрагдаагүй хүүхдүүд (хэсгийн эзлэх хувь)



Боловсролтой холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Хүүхдэд тулгамдаж буй үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)

